

## Өвчтөний эрх үүрэг

### I. Өвчтөний эрх

- Хуулинд өөрөөр заагаагүй тохиолдолд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг зөвхөн өвчтөнд мэдэгдэж түүнээс зөвшөөрөл авсны үндсэн дээр үзүүлж болно. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэхийг зөвшөөрсөн зөвшөөрлөө өвчтөн буцааж авч болно.
- Өвчтөн нь мэргэжлийн зохих түвшинд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах эрхтэй.
- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх явцад эрүүл мэндийн тусламж үйлчилгээний шинж чанар нөхцөлд тохируулж өвчтөнийг хүндэлж хүмүүнлэг харьцаж, түүний хувийн орон зайг нь хүндэтгэж харьцана.
- Өвчтөний эрүүл мэндийн шаардлага хэрэгцээг хангасан эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх эмнэлэг байгууллагаа өвчтөн сонгох эрхтэй.
- Өвчтөн тусламж үйлчилгээ үзүүлж буй эрүүл мэндийн байгууллагаасаа өөр бусад эрүүл мэндийн байгууллага болон эрүүл мэндийн ажилтнаас зөвлөгөө авах хүсэлт тавих эрхтэй.
- Өвчтөн эмнэлгийн Дотоод журамтай танилцах эрх үүрэгтэй.
- Эмнэлгийн тусламж үйлчилгээ түүний үр дүнг дүгнэх чадваргүй, хууль эрхийн чадамж нь хязгаарлагдмал өвчтөн хууль ёсны асран хамгаалагч буюу асран хамгаалагчаар томилогдсон хүнийг байнга хажуудаа хамт байлгах эрхтэй. .
- Эмнэлгийн Дотоод журам болон бусад хууль тогтоомжтой зөрчилдөхгүй мөн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэхэд эдгээр хүмүүс саад тотгор болохгүй тохиолдолд өвчтөн ойр дотны хүмүүсээ хажуудаа байлгах эрхтэй.
- Хэрэв өвчтөний эрүүл мэндийн байдал боломжтой тохиолдолд нийтийн эрүүл мэндийн даатгалын газраас төлдөггүй эсвэл хэсэгчилэн төлдөг эрүүл мэндийн тусламж үйлчилгээний үнийн тухай болон түүний төлбөрийг хийх арга замын тухай мэдээллийг өвчтөн урьдчилж авах эрхтэй.
- Эрүүл мэндийн ажилтан болон эрүүл мэндийн тусламж үйлчилгээ шууд үзүүлж буй ба тусламж үйлчилгээний явцад байлцаж буй эрүүл мэндийн ажилтны мэргэжлээр бэлтгэгдэж буй хүмүүс, сургалтынх нь нэгэн хэсэг болох үйлдэл гүйцэтгэж буй оюутан хүмүүсийн нэрийг өвчтөн асууж мэдэх эрхтэй.
- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэхэд шууд оролцоогүй хүмүүс ба эрүүл мэндийн ажилтны мэргэжлээр бэлтгэгдэж буй хүмүүс хажууд байх, оролцохыг өвчтөн татгалзах эрхтэй.
- Өвчтөн өөрийн бие эрүүл мэндийн байдлаа харгалзаж, эмнэлгийн Дотоод журамд зохицож бусад өвчтөний эрхийг хязгаарлахгүйгээр эмнэлэг эрүүл мэндийн байгууллага дотор эргэлт хүлээн авах эрхтэй..
- Өвчтөн өвчнөө цаг тухай бүрт нь оношлуулж эмчлүүлэх эрхтэй.
- Өвчтөнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх орчин нь өвчтөнийг аль болох хязгаарлахгүй, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй нөхцлийг хангасан байна.

## Өвчтөний эрх үүрэг

- Хууль эрхийн хязгаарлагдмал чадамжтай өвчтөнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэхэд түүний хажууд өвчтөнийг дарамталсан, хүчирхийлсэн буюу асран хамгаалах үүргээ үл биелүүлсэн гэж өвчтөн үзэж буй хүмүүсийг байлгахаас татгалзсан хүсэлт гаргаж болно.
- Эрүүл мэндийн шалтгааны улмаас мэдрэхүйн болон харилцааны бэрхшээлтэй өвчтөнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх үед харилцан ойлголцохын тулд түүнд ойлгомжтой арга сонгох мөн харилцан ойлголцох арга хэрэгслээ өвчтөн өөрөө сонгох, хоёрдагч хүнээр орчуулга хийлгэх зэрэг сонголтыг өвчтөн хийх эрхтэй.
- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх явцад өвчтөн словак хэлнээс бусад гадаад хэлнээс орчуулагч авах эрхтэй.
- Мэдрэхүйн болон бие бялдрын хөгжлийн бэрхшээлийн улмаас тусгай сургалттай нохой ашигладаг өвчтөний хувьд өвчтөний тухайн үеийн эрүүл мэндийн байдлын шаардлагын улмаас эмнэлгийн Дотоод журамд зохицож бусад өвчтөний эрхийг хязгаарлахгүйгээр нохой нь дагалдан хамт байж болно.
- Өвчтөн эрх бүхий ажилтны өмнө эрүүл мэндийн бичиг баримттай танилцах, өөрийн эрүүл мэндийн бичиг баримтаас тэмдэглэл хуулбар хийж авах эрхтэй.
- Өөрийн эрүүл мэндийн байдлын тухай, түүнд зориулсан эмчилгээний арга дарааллын тухай ба өөр бусад эмчилгээний тухай мэдээллийг хангалттай хэмжээнд ойлгомжтой авах эрхтэй.
- Өвчтөн өөрийн эрүүл мэндийн байдлын тухай, түүнд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай асуух, асуултандаа ойлгомжтой хариулт авах эрхтэй.
- Өөрийн эрүүл мэндийн байдлын тухай мэдээлэл өгөх хүсэлт гаргах эрхтэй ба тухайн хүсэлийг хэнд хүргүүлэх тухайгаа тодорхой зааж болно.
- Өвчтөний эрүүл мэндийн тухай мэдээлэл авах ба түүний эрүүл мэндийн бичиг баримттай танилцах, эрүүл мэндийн байдалтай холбоотой бусад бичиг баримттай танилцах, эдгээр бичиг баримтаас тэмдэглэл хийх хуулбар хийх зэрэг зөвшөөрөлтэй хүмүүсийн нэрийг өвчтөнийг хүлээн авах үед өгч болох ба мөн өвчтөний эрүүл мэндийн байдлаас шалтгаалан эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэхэд өөрөө зөвшөөрөл өгөх боломжгүй болох үед түүний өмнөөс зөвшөөрөл өгөх ба татгалзах хүнийг тодорхойлж зааж болно. Өвчтөний эрүүл мэндийн тухай мэдээлэл авах зөвшөөрөлгүй хүмүүсийн нэрийг өвчтөнийг хүлээх авах үед өгч тодорхойлж болох ба энэ хориогоо дараа нь хэзээ ч цуцалж болно.
- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэхийг зөвшөөрөх буюу татгалзах чадваргүй болтлоо өвчтөний эрүүл мэндийн байдал хүндэрсэн тохиолдол гарч болзошгүй гэж үзвэл өвчтөн зөвшөөрлөө (урьдчилж өгсөн хүсэлт) урьдчилж өгөх буюу мөн урьдчилан татгалзаж болно.
- Өвчтөн өөрийн бие эрүүл мэндийн байдлаа харгалзаж эмнэлгийн Дотоод журамд зохицож бусад өвчтөний эрхийг хязгаарлахгүйгээр БНЧУ-д бүртгэгдсэн шашны байгууллага ба шашны үйл ажиллагаа явуулах эрх бүхий

## Өвчтөний эрх үүрэг

хүнээс сүсэг бишрэл, сэтгэл санааны халамж дэмжлэг авах эрхтэй. Өвчтөний амь насанд аюул учирсан ба түүний эрүүл мэнд ноцтой хохирсон тохиолдолд шашны санваартан өвчтөн дээр ирэхийг хориглож болохгүй.

## II. Өвчтөний үүрэг

- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэхийг зөвшөөрсөн бол өвчтөн эмчилгээний журам дэглэм сахих үүрэгтэй..
- Эмнэлгийн дотоод журмыг мөрдөх үүрэгтэй.
- Нийтийн эрүүл мэндийн даатгалын газраас төлдөггүй буюу хэсэгчилэн төлдөг эрүүл мэндийн тусламж үйлчилгээний үнийг тусламж үйлчилгээ үзүүлсэн эмнэлэгийн байгууллагад төлөх үүрэгтэй.
- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай халдварт өвчин, урьд өмнө нь эмчлүүлж байсан тухай, хэрэглэдэг эм бэлдмэлийн тухай, мансууруулах донтуулагч бодис хэрэглэдэг эсэх зэрэг өөрийн эрүүл мэндийн байдлын тухай үнэн зөв мэдээллийг Эмчлэгч эмч ба эрүүл мэндийн ажилтанд өгнө.
- Эмчилгээний явцад согтууруулах ундаа ба мансууруулах донтуулагч бодис хэрэглэхгүй байх, шалтгаан бүхий тохиолдолд эмчлэгч эмчийн шийдвэрийг үндэслэн согтууруулах ундаа ба мансууруулах донтуулагч бодис илрүүлэх шинжилгээ өгөх үүрэгтэй.
- Эрүүл мэндийн тусламж үзүүлж буй байгууллага, тус байгууллагын ажилтан шаардсан тохиолдолд өвчтөн, өвчтөний хууль ёсны асран хамгаалагч, өвчтөний тогтоосон хүн, өвчтөний ойр дотны хүн, гэр бүл хамт амьдрагч зэрэг хүмүүс биеийн байцаалт бичиг баримтаа шалгуулна. Хууль тогтоомжийн дагуу өвчтөний эрүүл мэндийн байдлын тухай мэдээлэл авах эрх бүхий хүн, өвчтөнийг эргэж ирсэн хүн биеийн байцаалт бичиг баримтаа шалгуулах үүрэгтэй. Гадаадын иргэд гадаад паспорт буюу өөр бусад биеийн байцаалт бичиг баримтаа шалгуулна. Эмнэлэг эрүүл мэндийн байгууллагын ажилтан эргэлзэж байвал, өвчтөний ойр дотны хүн өөрийн хаяг, биеийн байцаалт бичиг баримтын дугаар зэргийг бичсэн гэрчлэх үнэн зөвийн мэдүүлэг бичиг бичиж батална. Энэхүү үнэн зөвийн мэдүүлгийг эрүүл мэндийн бичиг баримтанд хавсаргана. Өвчтөн эргэлтэнд зөвшөөрөл өгч чадахгүй тохиолдолд биеийн байцаалт бичиг баримтаа шалгуулахаас татгалзсан хүнийг эрүүл мэндийн ажилтан өвчтөн дээр эргэлтээр оруулахаас татгалзана.

**Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх, түүний нөхцлийн тухай 372/2011 тоот хууль, нэмэлт.**

**Боловсруулсан: NPK чанарын удирдлагын хэлтэс.**

**Огноо: 2016.08.01**